

Хятад маягийн модернизаци

Мөнхөөгийн Эрдэнэбаяр 

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

erdenebayar_m@mas.ac.mn

Хураангуй: БНХАУ-ын бодлого тодорхойлогчид тус улсын чинээлэг, хүчирхэг болох арга зам нь бусад өндөр хөгжссөн улсын нэгэн адил модернизацид бүх талаар хүрэх хэмээн үзэж байна. Гэхдээ тус улсын модернизацийн үйл явц өөрийн гэсэн онцлогтой байх бөгөөд цаашид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн загвар болгон төлөвшүүлэхийг зорьж буй ажээ. Уг үйл явцад гадаад болон дотоод багагүй сорилт байгаагаас улс төрийн тогтолцоог хэрхэн шинэчлэхээс амжилттай хэрэгжих эсэх нь хамаарах магадлалтай юм.

Энэхүү өгүүллийн эхний хэсэгт модернизаци хэмээх ойлголт, онолын талаар товч тайлбарлаж, хоёрдугаар хэсэгт Хятадын модернизацийн ерөнхий үйл явц болон “хятад маягийн модернизаци”-ийн голлох зорилт, онцлогийг авч үзэн, гуравдугаар хэсэгт хэрэгжих боломж, тулгарч болох сорилтын талаар санал бодлоо хуваалцлаа.

Түлхүүр үгс: Модернизаци, хятад маягийн модернизаци, боломж, сорилт

Эхлэл

БНХАУ-ын улс төрийн чухал үйл явдал болох Хятадын коммунист нам (цаашид ХКН гэх)-ын 20-р их хурал 2022 оны 10 дугаар сард хуралдаж тус намын Ерөнхий нарийн бичгийн

даргаар Ши Жиньпинийг дахин сонгосон билээ. Ингэснээр тэрээр ХКН-ыг удирдах гурав дахь бүрэн эрхийнхээ хугацааг эхлүүлж, Мао Зэдунээс хойш тодорсон хамгийн



нөлөө бүхий удирдагч болж байна.¹ Ши Жиньпин тус хуралд тавьсан улс төрийн илтгэлдээ Хятад үндэстний агуу их сэргэн мандлыг “хятад маягийн модернизац”-аар иж бүрэн ахиулах талаар онцолсон нь олны анхаарлыг татав. Тодруулбал, ХКН-ын гол үүрэг бол тус улсыг “орчин үеийн чинээлэг, хүчирхэг социалист улс” болгон хөгжүүлэх, ийнхүү хүчирхэг улсыг бий болгох арга зам, загвар нь “хятад маягийн модернизац” байх ажээ. Хятад маягийн модернизацийг хэрэгжүүлэх энэхүү үзэл санаа нь цоо шинэ зүйл биш юм. 2012 онд Ши Жиньпин

ХКН-ын даргаар эхний удаа сонгогдсоныхоо дараа “хятад мөрөөдөл”² хэмээх шинэ үзэл санааг тунхаглаж, мөн онд ХКН-ын 18-р их хурлаас “орчин үеийн социалист улсыг цогцоор байгуулах”, улмаар 2021-2025 онд тус улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх “14-р таван жилийн төлөвлөгөө”-нд 2035 он гэхэд “социалист модернизац”-ийг бүрэн бий болгох зэрэг зорилт дэвшүүлсэн байдаг. Улмаар ХКН-ын энэ удаагийн их хурлаар “хятад маягийн модернизац” хэмээн тодотгон томъёолж байна.

Нэг. Модернизацийн онол

Модернизацийн онол анх 1950-аад оны үед барууны орнуудад үүсэн бий болсон бөгөөд хэд хэдэн сургуульд хуваагддаг, олон эрдэмтэн өөрийн гэсэн байр суурь, тодорхойлолтыг гаргасан байдаг. Тухайлбал, У.Мур, А.Экстайн нар модернизацийг үйлдвэржилтээс, К.Гриффин хөдөө аж ахуйн шинэчлэлтээс, М.Леви хөгжилтэй орнуудын эрчимтэй тусламжаас, С.Эйзенштадт нийгмийн өөрчлөлтийг харгалзахаас, У.Шрам шинэ үнэт зүйлс болон нийгмийн коммуникациас, Б.Хиггинс хөгжлөөс эхлэх ёстой хэмээн үзсэн байдаг.³ Харин С.Хантингтон модернизацийг “энэ бол хувьсгалт үйл явц, цогц үйл

явц, системчилсэн үйл явц, дэлхий дахины үйл явц, урт хугацааны болон үе шаттай үйл явц, адил төрлийн үйл явц (дэлхийн соёл, даяаршил гэх мэт), эргэлт буцалтгүй дэвших үйл явц (ядуугаас баян руу, сулаас хүчтэй рүү гэх мэт)” хэмээн дүгнэсэн. Түүнчлэн хөгжлийн онолчид модернизацийг үе шаттай үйл явц гэж үздэг, тухайлбал, Ростов улс орнууд уламжлалт нийгмээс масс хэрэглээний нийгэм хүртэлх хөгжлийн таван үе шатыг туулж байж бүрэн хөгжилд хүрнэ хэмээн үзсэн байна. Модернизацийн онолын бас нэг онцлог бол соёлын болон нийгмийн шинэчлэлтийг чухалчлахаас гадна улс төрийн хөгжил мөн бий болох ёстой

¹ Аюулгүй байдал судлалын хүрээлэн, ХКН-ын XX их хурал: Ши Жиньпиний гурав дахь бүрэн эрхийн хугацаа, 2022-11-11, <https://niss.gov.mn/archives/2793>

² Хятад мөрөөдөл нь товчдоо, тус улс үндэстний хувьд сэргэн мандах, чинээлэг, хүчирхэг болох, ард иргэд нь аз жаргалтай байх тухай, тодруулбал, ХКН байгуулагдсаны 100 жилийн ой буюу 2021 он гэхэд дунд зэргийн чинээлэг нийгмийг бүрэн байгуулах, цаашлаад БНХАУ байгуулагдсаны 100 жилийн ой буюу 2049 он гэхэд орчин үеийн, чинээлэг, хүчирхэг социалист улсыг бүрэн байгуулах гэсэн “хоёр 100 жилийн зорилт”-ыг дэвшүүлсэн байдаг.

³ О.Багтулга, Улс төрийн хөгжил ба модернизац, Шинэ толь №18, 1997

гэж үздэг. Тухайлбал, Хантингтон, Фукуяама зэрэг эрдэмтэн улс төрийн институцгүй шилжилт улс төрийн задрал ялзралд хүргэдэг, төрийг бэхжүүлэх буюу хууль дээдлэх ёс, ардчилсан хариуцлагын механизм бүхий орчин үеийн төртэй болж байж модернизацид хүрнэ хэмээн үзсэн байдаг.⁴

Товчдоо, модернизацйг хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн хувьсгалын нөлөөн дор эдийн засаг, улс төр, нийгмийн бүтэц, соёл, хүний хөгжлийн хувьд уламжлалт байдлаас орчин үеийн болох динамик хөгжлийн үйл явц гэж үзэж болох юм. Харин аливаа улсын хувьд модернизац зайлшгүй боловч хэрэгжүүлэх арга зам, загварын хувьд өөр өөр байж болох

ажээ. Тухайлбал, Г.Рэйс модернизацйн дөрвөн загвар байна хэмээн үзсэн: 1-рт, Хувьсгалт модернизацйн загвар, үүнд Англи, Америк зэрэг орнууд ардчилал, хотжилт, шашингүй үзэл зэргийг бий болгосон; 2-рт, Зүүн азийн модернизац, энд Өмнөд Солонгос, Хятад зэрэг орнууд чөлөөт худалдааг дэмжсэн авторитари дэглэмээр орчин үежилтийг бий болгосон; 3-рт, Газрын тосны ордтой орнуудын загвар, энэ загвар эдийн засгийн хувьд олон талаасаа орчин үежилтийг бий болгосон боловч үзэл санаа, оюун ухаан, улс төрийн дэглэмийн хувьд уламжлалт хэвээр үлдсэн; 4-рт, Орчин үеийн ОХУ-ын загвар, үндэсний үзэлд суурилсан модернизац.⁵

Хоёр. Хятад маягийн модернизац

Хятадын модернизац ерөнхийдөө Зүүн азийн модернизацид хамаарах бөгөөд товчдоо, зах зээлийн эдийн засгийг дэмжсэн авторитар дэглэмээр аж үйлдвэржилт, эдийн засгийн хувьд модернизацйг бий болгосон.⁶ Уг үйл явц үе шаттай, хэсэгчилсэн байдлаар хийгдсэн бөгөөд эдийн засгийн либералчлал, улс төрийн консерватизмаас бүрдсэн хэсэгчилсэн шинэтгэл гэж нэрлэгддэг.

Хятадын модернизацйн үйл явцыг Манж чин улс мөхөж, бүгд найрамдах улс байгуулагдсанаар эхэлсэн гэж дийлэнх судлаач үздэг. 1911 оны

Синхайн хувьсгалыг удирдсан Сун Ятсений хувьд, Хятадын модернизац нээлттэй байдлыг баримталж, Европ, АНУ-ын туршлагаас суралцах хэрэгтэйг онцолж байжээ. Гэхдээ энэ үйл явц бие даасан байх ёстой бөгөөд “Хятадын хөгжлийн бодит хэрэгцээг дагаж, өөрийн замаар явах” нь Хятадад модернизацйг хэрэгжүүлэх боломжийг олгоно хэмээн үзсэн. Харин олон жилийн иргэний дайны дараа 1949 онд “шинэ хятад” буюу БНХАУ байгуулагдахад тус улсын удирдагч Мао Зэдун үндсэндээ “Сталины загвар”-ыг ашигласан “социалист

⁴ F.Fukuyama, Reflections on Chinese governance, Journal of Chinese Governance, 2016 Vol. 1, No. 3, 379–391

⁵ А.Бат-Оргил, Хөгжлийн тухай онолууд Монголын хөрсөнд, Номад паблишинг, 2018 он Улаанбаатар хот

⁶ Хятад Улс ХАА-н орноос аж үйлдвэржсэн орон болсон, үүнийг тус улсын дэлхийн боловсруулах аж үйлдвэрийн 30 орчим хувийг дангаар бүрдүүлж, тэргүүлж байгаагаас харж болно.

модернизац”-ыг хэрэгжүүлэх сонголт хийсэн. Улмаар 1950-1960 оны үед ХКН-аас “дөрвөн модернизац” буюу аж үйлдвэр, хөдөө аж ахуй, батлан хамгаалах болон шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх стратегийн зорилт дэвшүүлэн ажилласан байдаг. Хэдийгээр Маогийн үед тус улс олон улсын харилцааны болон дотоодын улс төр, эдийн засгийн гүнзгий хямралд нэрвэгдсэн боловч тэр үед өнөөгийн Хятадын хүнд үйлдвэрийн үндэс суурь тавигдсан хэмээн үзэх үндэстэй.⁷

1978 оноос эхэлсэн эдийн засгийн үсрэнгүй хөгжлийг авчирсан “Шинэтгэл, нээлттэй бодлого”-ын улс төрийн инженер Дэн Сяопин Хятадын модернизацийн замыг, “Бидний орчин үежих бүтээн байгуулалт Хятадын бодит байдлаас эхлэх ёстой. Хувьсгал, бүтээн байгуулалт аль нь ч байсан гадаадын туршлагаас суралцахад анхаарах хэрэгтэй. Гэхдээ бусад улсын туршлага, загварыг шууд хуулбарлах нь хэзээ ч амжилтад хүргэж байгаагүй. Энэ талаар бидэнд багагүй сургамж бий. Марксизмын түгээмэл үнэнийг өөрийн өвөрмөц бодит байдалтай хослуульж, өөрсдийн замаар алхаж, Хятадын онцлогтой социализмыг байгуулах нь бидний олон жилийн түүхэн туршлагаас гарсан үндсэн дүгнэлт юм” хэмээн тодорхойлсон.⁸ Улмаар “шинэтгэл, нээлттэй бодлого” эхэлснээр ХКН тус улсын модернизацийн үйл явцад стратегийн зохицуулалт хийж, “гурван

алхам” хэмээх хөгжлийн стратеги дэвшүүлсэн байдаг. Энэ нь товчдоо, тус улсын эдийн засгийг хөгжүүлэх гурван үе шат бүхий стратеги бөгөөд 1-р шатанд, 1981 оноос 1980-аад оны эцэс гэхэд 1980 оны ҮНБ-ийг хоёр дахин нэмэгдүүлэх, иргэдийн идэх, өмсөх зэрэг наад захын хэрэгцээг хангах; 2-р шатанд, 1991 оноос 20-р зууны төгсгөл үе гэхэд ҮНБ-ийг дахин хоёр дахин нэмэгдүүлэх, иргэдийн амьдрал боломжийн түвшинд очих; 3-р шатанд, 21-р зууны дунд үе гэхэд нэг хүнд ногдох ҮНБ дунд зэргийн хөгжилтэй орны хэмжээнд хүрч, иргэдийн амьдрал харьцангуй чинээлэг болж, модернизацийг үндсэндээ хэрэгжүүлнэ хэмээн тооцоолж байжээ. Шинэтгэл, нээлттэй бодлогын үрээр Хятадын ДНБ хоёр оронтой тоогоор өсч, 1999 дунд орлоготой, 2010 онд дундаас дээгүүр орлоготой орнуудын эгнээнд орсон. 2009 онд тус улс дэлхийн хоёр дахь том эдийн засаг, 2010 онд дэлхийн хамгийн том экспортлогч орон болжээ. Гэхдээ энэхүү 30 гаруй жилийн эдийн засгийн хурдацтай өсөлтийн дараа, тус улсын эдийн засгийн нөөцүүдийн үнэ, ашигт байдал аажмаар өөрчлөгдөж, хямд үнэтэй экспортыг түшиглэж байсан хөгжлийн загвар нь томоохон сорилттой тулгарсан. Тухайлбал, ДНБ-ний хурдтай өсөлт бүтцийн тэнцвэргүй байдал, орлогын тэгш бус байдал, байгаль орчны бохирдол, нөөцийн хомсдол зэрэг асуудлыг дагуулсан байдаг. Улмаар Ши Жиньпин 2012 онд ХКН-ын даргаар сонгогдсоныхоо

⁷ 姜新立, 《走共同富裕的道路: 解读「中国式现代化」》, 2022-11, https://www.hk01.com/article/832326?utm_source=01articlecopy&utm_medium=referral

⁸ 姜新立, 《走共同富裕的道路: 解读「中国式现代化」》, 2022-11, https://www.hk01.com/article/832326?utm_source=01articlecopy&utm_medium=referral

дараагаас “хятад мөрөөдөл”, “шинэ хэвшил” зэрэг олон шинэ үзэл санаа, бодлого стратеги гаргаж, тус улсын хөгжлийн арга замыг сайжруулах, шинэ шатанд гаргах оролдлого хийсээр ирсэн. Өөрөөр хэлбэл, Хятадын модернизац хаант засаглалыг халснаар эхэлж, Мао Зэдуны загвараас Дэн Сяопиний загварт хүрч, улмаар Ши Жиньпиний үеийн шинэ үе шатанд орж буй ажээ.

Тэгвэл Ши Жиньпиний “шинээр” дэвшүүлсэн “хятад маягийн модернизац” гэж юуг ойлгох, ямар онцлогтой байна вэ. Түүний ХКН-ын 20-р их хуралд тавьсан илтгэлд томъёолсноор, уг модернизац нь БНХАУ байгуулагдсанаас хойш, ялангуяа 1978 оноос эхэлсэн “шинэтгэл, нээлттэй бодлого”-оос хойших урт хугацааны эрэл хайгуул, практикт үндэслэн, ХКН-ын 18-р их хурлаас хойш гаргасан онол, практикийн шинэ ололтоор өргөжүүлсэн, ХКН-аар удирдуулсан “социалист модернизац” байх бөгөөд дэлхийн бусад улсын модернизацийн нийтлэг шинжийг агуулах төдийгүй өөрийн улс үндэстний нөхцөл байдалд тулгуурласан Хятадын онцлогтой байх ажээ.

Хятад маягийн модернизац нь асар их хүн амын модернизац бөгөөд бүх иргэдийнхээ хамтын хөгжил цэцэглэлтийн төлөө, материаллаг болон оюуны соёл иргэншлийг уялдуулсан, хүн ба байгаль зохицон орших, энх тайванч хөгжлийн замаар замнах зэрэг

голлох онцлогтой бол ХКН уг үйл явцыг удирдах, Хятадын онцлогтой социализмыг тууштай баримтлах, өндөр чанартай хөгжлийг бий болгох, ардын ардчиллын бүх үйл явцыг хөгжүүлэх, ард иргэдийн оюун санааны ертөнцийг баяжуулах, хүн төрөлхтний соёл иргэншлийн шинэ хэлбэрийг бий болгох зэрэг шаардлагыг агуулж байна.⁹

Тус улсын 14-р таван жилийн төлөвлөгөөнд 2035 он гэхэд социалист модернизацийг бүрэн бий болгох талаар тусгасан бөгөөд товчдоо, шинжлэх ухаан, эдийн засаг, засаглал, боловсрол, соёл, байгаль орчин, батлан хамгаалахын салбарт дараах зорилтуудыг хангаснаар зорилгодоо хүрсэн хэмээн үзэх ажээ.

- Эдийн засгийн, шинжлэх ухаан технологийн, улсын ерөнхий хүчин чадал тус тус эрс нэмэгдэж, нэг хүнд ногдох ДНБ дунд зэргийн хөгжингүй орнуудын түвшинд хүрэх;¹⁰
- Өндөр түвшний шинжлэх ухааны бие даасан хүчирхэг байдлыг бий болгож, инновацлаг орнуудын тэргүүн эгнээнд орох;
- Орчин үеийн эдийн засгийн тогтолцоог бүтээж, хөгжлийн шинэ хэв маягийг бүрдүүлж, шинэ үйлдвэржилт, мэдээлэлжүүлэлт, хотжилт, хөдөө аж ахуйг бий болгох;
- Улсын засаглалын тогтолцоо болон чадамжийг

⁹ ХКН-ын XX их хурлын нээлтээр тус намын төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпиний хэлэлцүүлсэн илтгэл, 2022.10.16

¹⁰ Ши Жиньпин "2035 он гэхэд тус улсын эдийн засгийн нийт хэмжээ болон нэг хүнд ногдох дундаж орлогыг 2 дахин нэмэгдүүлэх бүрэн боломжтой" хэмээсэн.

- шинэчилж, ард түмний ардчилсан тогтолцоог улам төгөлдөржүүлж, хуулиар засагладаг улс, засгийн газар, нийгмийг бүтээн байгуулах;
- Боловсрол, шинжлэх ухаан, хүний нөөц, соёл урлаг, спортын хүчтэй улс, эрүүл Хятад улсыг бүтээн байгуулж, улсын соёлын зөөлөн хүчийг үлэмж нэмэгдүүлэх;
 - Ард түмний амьдралыг улам аз жаргалтай болгох, дунд орлоготой бүлгийнхний эзлэх хувийг эрс нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний тэгш байдлыг хангах, хөдөө орон нутагт орчин үеийн амьдралын үндсэн нөхцөлийг бүрдүүлэх, хүний бүх талын хөгжил болон иргэдийн нийтлэг чинээлэг байдлыг бодитоор ахиулах;
 - Ногоон үйлдвэрлэлийн хэв маягийг өргөнөөр бүрдүүлж, нүүрсхүчлийн хийн
- ялгаруулалтыг дээд цэгт хүргэж, улмаар тогтвортой бууруулан, экологийн орчныг үндсээр нь сайжруулж, үзэсгэлэнт Хятад улсыг бүтээн байгуулах;
- Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо, чадавхыг бүх талаар хүчирхэгжүүлж, батлан хамгаалах болон цэргийн шинэчлэлтийг үндсэнд нь бий болгоно.¹¹

Дүгнэвэл, хятад маягийн модернизац тус улсын модернчлагдах үйл явцын дараагийн шатыг эхлүүлж буй бөгөөд өмнөх үе шатны сул талыг нөхөх, модернизацийг цогцоор бий болгоход чиглэж байна (Хүснэгт 1-ийг үзнэ үү). Харин үндсэн хоёр “онцлог” байгаа нь 1-рт, энэхүү үйл явц ХКН-ын удирдлага дор өрнөх, 2-рт, хятад маягийн модернизац марксизмын онолыг баяжуулсан шинж чанартай бөгөөд социалист хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх ажээ.

¹¹ 中华人民共和国国民经济和社会发展第十四个五年规划和2035年远景目标纲要, https://www.ndrc.gov.cn/xxgk/zcfb/ghwb/202103/t20210323_1270124.html;

Хүснэгт 1. Хятадын модернизацийн үйл явцын товч тойм: 1840-2080

Хугацаа (ойролцоогоор)	Үе шат / ололт амжилт	Онцлог / үр дүн	
1840-1860	Эхлэл үе		
Өмнөх үе	1840-1911	Манж чин гүрний төгсгөл үеийн модернизац	Үйлдвэржилт нэгдүгээрт
	1912-1949	Дундад иргэн улсын үеийн хэсэгчилсэн модернизац	Үйлдвэржилт нэгдүгээрт
	1949-2020	Шинэ хятад улсын модернизац	Дөрвөн модернизац, гурван алхам зэрэг хөгжлийн стратеги
	1840-2020 (180 жил)	1840-1949, Модернизацийн эхэн үе, хэсэгчилсэн модернизац хэрэгжүүлэв. 1950-2018, Эхний шатны модернизацийг дуусгаж, буурай хөгжилтэй орноос хөгжиж буй орны дунд түвшинд хүрэв. 2000-2020, Дунд зэргийн чинээлэг нийгмийг иж бүрэн байгуулав.	
Цаашдын төлөв	2020-2035	Хоёр дахь шатны модернизацид орж, дэлхийн дунд түвшний хөгжингүй орны хэмжээнд очно. Модернизацийн түвшнээр дэлхийн эхний 40 улсад багтана.	Модернизацийг үндсэндээ хэрэгжүүлнэ.
	2035-2050	Өндөр хөгжилтэй орны түвшинд хүрч, модернизацийн түвшнээр дэлхийн эхний 20 улсад багтаж, орчин үеийн социалист хүчирхэг гүрэн болон бүрэн төлөвшинө.	Модернизацийг улс даяар нийтлэг хэрэгжүүлсэн байна.
	2050-2080	Хоёр дахь шатны модернизацийг дуусгаж, улсын дундаж үзүүлэлт дэлхийн тэргүүлэх түвшинд хүрнэ. Модернизацийн түвшнээр дэлхийн эхний 10 улсад багтана.	Модернизацийг иж бүрэн хэрэгжүүлсэн байна.
	2020-2080 (60 жил)	2020-2050, анхан шатны хөгжингүй орноос өндөр хөгжилтэй орон болох, орчин үеийн хүчирхэг улс болон бүрэн төлөвших; 2050-2080, хөгжингүй орноос дэлхийн тэргүүлэгч орон болон дэвших, модернизац болон үндэстний агуу их сэргэн мандлыг бүрэн хэрэгжүүлэх;	

Эх сурвалж: Хятадын ШУА-ийн Модернизацийн судалгааны төвийн дарга Хө Чуанчи, Хятадын модернизацийн үйл явцын товч тойм, “Хятадын модернизацийн тайлан 2021” шинжээчдийн хэлэлцүүлэг; 中国科学院中国现代化研究中心主任何传启, 中国现代化进程的时间简表, 《中国现代化报告2021》专家座谈会.

Гурав. Боломж ба сорилт

Тус улс 14-р таван жилийн төлөвлөгөөндөө 2035 он гэхэд социалист модернизацийг бүрэн бий болгох, үүнд, шинжлэх ухаан, технологийн хүч чадлыг огцом өсгөх, эдийн засгийн нийт хэмжээ, нэг хүнд ногдох орлогоо дунд зэргийн хөгжингүй орнуудын түвшинд хүргэх, инновацаар дэлхийн тэргүүлэгчдийн нэг болох зэрэг голлох зорилт дэвшүүлсэн.

Эдийн засгийн хэмжээ, орлогын зорилгын хувьд хэдийгээр эдийн засгийн өсөлт удааширсан, хувийн хэвшил хүндхэн байгаа, өрийн хэмжээ нэмэгдсэн, хүн амын хөгшрөлт, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа зэрэг томоохон сорилт байгаа ч харьцангуй биелэх магадлал өндөр юм. Ирэх 10-15 жилийн хугацаанд тус улс ДНБ-нээ жилд дунджаар 4.4%-иар өсгөж чадвал “дунд орлогын хавх”-аас мултарч, өндөр орлоготой орнуудын эгнээнд нэгдэх боломжтой.¹² Тус улсын ДНБ-ны сүүлийн жилүүдийн өсөлтийг харвал, 2021 онд 8.1%, 2022 онд 3% өссөн, харин 2023 онд 5% орчим өсгөх зорилтыг тавиад байна. Гэхдээ модернизац зөвхөн орлогоор тодорхойлогдохгүй юм. Энэ нь соёл, нийгэм, эдийн засгийн шинэчлэлээс гадна улс төрийн хөгжлийг мөн

шаарддаг, өөрөөр хэлбэл, нийгэм, эдийн засаг болон улс төрийн хөгжил нэг нь нөгөөгөө хөтөлдөг цогц үйл явц. Харин тус улсын хувьд, хэдийгээр орчин үеийн төрийг хоёр мянга гаруй жилийн өмнөөс хөгжүүлсэн боловч төрийн эрх мэдлийг хязгаарласан хуулийн засаглалд хараахан хүрч чадаагүй, ХКН-ын удирдлага дахь Хятадын өнөөгийн засгийн газар “династ”-ийн засаглалын олон шинж чанарыг давтаж буй бөгөөд улс төрийн тогтолцоогоо ч мөн адил өөрчлөхгүй бол “шинэ хэвшил”¹³ рүү шилжихэд амаргүй байх ажээ. Хурдацтай өөрчлөгдөж буй орчин нөхцөлд илүү их дасан зохицох чадвар, системийн хэмжээнд илүү их үзэл санаа, үйл ажиллагааны эрх чөлөө шаардлагатай ба хамгийн чадварлаг намын удирдлага ч энэ үйл явцыг дээрээс удирдах боломжгүй ажээ.¹⁴ Гэвч тус улсын эрх баригчдын сүүлийн үеийн бодлого, шийдвэр төрийн хяналтыг нэмэгдүүлэх талруу өөрчлөгдөж байна.

Шинжлэх ухаан, технологийн зорилгын хувьд мөн харьцангуй биелэх боломж өндөр. 2022 оны байдлаар тус улсын судалгаа, шинжилгээнд зориулсан зардал 551 тэрбум ам.долларт хүрч, энэ үзүүлэлтээр

¹² JP Morgan, Asset management, China's path to becoming a higher income country, <https://am.jpmorgan.com/br/en/asset-management/adv/insights/ltema/the-next-phase-of-chinas-growth/>

¹³ 2014 онд Ши Жиньпин тус улсын эдийн засаг шинэ хэвшилд шилжиж буй болон энэ нь хэд хэдэн онцлогтой болохыг зарласан. Үүнд, 1-рт, эдийн засгийн өндөр хурдацтай өсөлтөөс дунд хурдацтай хөгжилд шилжих; 2-рт, эдийн засгийн бүтцийг сайжруулж, аажмаар үйлчилгээний салбарыг эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болгох, хот хөдөө, бүс нутаг хоорондын хөгжлийн ялгааг багасган иргэдийн орлогыг нэмэгдүүлэх; 3-рт, тулгуур хүчин зүйлийн шилжилт буюу хөрөнгө оруулалтын тулгуураас инновацийн тулгуурт шилжих гэсэн зорилтууд багтаж буй.

¹⁴ F.Fukuyama, Reflections on Chinese governance, *Journal of Chinese Governance*, 2016 Vol. 1, No. 3, 379–391

дэлхийд АНУ-ын дараа 2-рт жагссан.¹⁵ Мөн ГП буюу олон улсын инновацын индексээр 132 орноос 11-р байранд эрэмбэлэгдэж байна.¹⁶ Улмаар 14-р таван жилийн төлөвлөгөөндөө “судалгаа, шинжилгээнд зориулах зардлыг жилийн 7%-иас дээш өсгөхийг хичээх, хиймэл оюун, квант тооцоолол, хагас дамжуулагч, мэдрэл судлал, ген ба биотехнологи, эмнэл зүй ба эрүүл мэндийн үйлчилгээ, нэгдсэн эрчим хүчний сүлжээ, сансар, далайн

гүн, туйлын хайгуулыг чухалчлан хөгжүүлэх” зорилт дэвшүүлээд байна.

Гэхдээ тус улс чип, хагас дамжуулагч зэрэг орчин үеийн чухал технологийн хувьд гадаадаас хараат хэвээр байгаа бөгөөд Хятад, АНУ-ын стратегийн өрсөлдөөнөөс үүдсэн барууны болон зүүн азийн хөгжингүй орнуудын технологийн тусгаарлах бодлого багагүй сорилт учруулах нь тодорхой юм.

Дүгнэлт

Хятад мөрөөдөл буюу орчин үеийн чинээлэг, хүчирхэг, дэлхийн тэргүүлэгч улсыг бүтээн байгуулах арга зам нь бусад хөгжингүй улсын нэгэн адил модернизацийн арга зам байх ажээ. Барууны улс орнуудын модернизацид эдийн засгийн хөгжлөөс гадна хувь хүний бус төр, хууль дээдлэх ёс, ардчилсан хариуцлагын механизм зэрэг улс төрийн тогтолцооны хөгжил мөн чухал нөлөө үзүүлсэн бол Хятадын хувьд өөрийн гэсэн онцлогтой нэг намын тогтолцоо бүхий “социалист” арга замаар модернизацид бүрэн хүрч болохыг дэлхий нийтэд харуулах амбицтай байна. Ши Жиньпиний “шинээр” тодорхойлж буй “Хятад маягийн модернизац” нь тус улсын модернчлагдах үйл явцын “дутууг гүйцээх, дундуурыг дүүргэх” дараагийн үе шат бөгөөд

материаллаг хөгжлөөс гадна оюуны хөгжил, ногоон хөгжил, соёлын хөгжил зэрэг тогтвортой хөгжлийн бусад үзүүлэлтийг хангах, шинжлэх ухаан, боловсрол, засаглал, хөдөө аж ахуй, батлан хамгаалах зэрэг бүхий л салбарт модернизацийг бий болгоход чиглэж байна. Тус улсын энэхүү “их аян”-д гадаад болон дотоод орчны, үүнээс нийгэм, эдийн засгийн олон сорилт байгаагаас нэг намын төр, нийгэм дэх үнэмлэхүй хяналт нь өөрөө уг үйл явцын голлох сорилт болох магадлалтай. Учир нь илүү өндөр түвшний хөгжлийн үе шат буюу оюуны хөгжлийг дээдэлсэн, мэдлэг, инновацид суурилсан үе шат руу шилжин ороход илүү их үзэл санаа, үйл ажиллагааны эрх чөлөө, улс төрийн хариуцлагын тогтолцоо шаардагдах нь дамжиггүй.

¹⁵ <https://www.statista.com/statistics/732247/worldwide-research-and-development-gross-expenditure-top-countries/>

¹⁶ Global Innovation Index 2022, https://www.wipo.int/edocs/pubdocs/en/wipo_pub_2000_2022/cn.pdf

Ном зүй

1. Аюулгүй байдал судлалын хүрээлэн, ХКН-ын ХХ их хурал: Ши Жиньпиний гурав дахь бүрэн эрхийн хугацаа, 2022-11-11, <https://niss.gov.mn/archives/2793>
2. 姜新立, 《走共同富裕的道路: 解讀「中國式現代化」》, 2022-11, https://www.hk01.com/article/832326?utm_source=01articlecopy&utm_medium=referral
3. 当代中国与世界研究院, “三步走”发展战略, http://keywords.china.org.cn/2022-07/11/content_78317156.html
4. А.Бат-Оргил, Хөгжлийн тухай онолууд Монголын хөрсөнд, Номад Публишинг, 2018 он Улаанбаатар хот
5. ХКН-ын ХХ Их хурлын нээлтээр тус намын төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпиний хэлэлцүүлсэн илтгэл, 2022.10.16
6. 中国科学院中国现代化研究中心主任何传启, 中国现代化进程的时间简表, 《中国现代化报告2021》专家座谈会, 2021年11月25日, 北京
7. JP Morgan, Asset management, China's path to becoming a higher income country, <https://am.jpmorgan.com/br/en/asset-management/adv/insights/lcma/the-next-phase-of-chinas-growth/>
8. F.Fukuyama, Reflections on Chinese governance, Journal of Chinese Governance, 2016 Vol. 1, No. 3, 379–391
9. 中华人民共和国国民经济和社会发展第十四个五年规划和2035年远景目标纲要, https://www.ndrc.gov.cn/xxgk/zcfb/ghwb/202103/t20210323_1270124.html;
10. <https://www.statista.com/statistics/732247/worldwide-research-and-development-gross-expenditure-top-countries/>
11. Global Innovation Index 2022, https://www.wipo.int/edocs/pubdocs/en/wipo_pub_2000_2022/cn.pdf

Chinese-style modernization

Erdenebayar Munkhuu

Ph.D

Institute of International Studies,

Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

erdenebayar_m@mas.ac.mn

Abstract: *The policymakers in China consider that the way towards wealthy and powerful nation would be to achieve modernization in all aspects as many other developed countries did so. However, the modernization process in China has its own characteristics and, moving forward, it is intended to be developed into an internationally recognized model. Since there are a number of external and internal challenges may be encountered during the process including a proper reformation of the political system that could have a decisive impact on the successful modernization.*

The first part of this article will briefly explain what the modernization is and the theory of modernization, while the second part outlines the overall process of modernization in China and the main features and goals of “Chinese-Style Modernization”. In the final part, the author shares his views on the possibilities of implementation and the challenges that may be faced.

Keywords: *Modernization, Chinese-Style Modernization, Challenges and Opportunities*

Submission Date: 2023.06.12

Completion of Review: 2023.06.30

Final Decision for Acceptance: 2023.10.02